

БАТЛАВ. ГҮЙЦЭГТГЭХ ЗАХИРАЛ



Э.НОМИН ЧУЛУУН

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Техникийн нөхцөл хүссэн хуулийн этгээдийн нэр: "Багануур" ХК Багануур дүүрэг, компанийн өөрийн байр

Техникийн нөхцөл хүссэн газрын байршил: Багануур дүүрэг нүүрсний уурхай

Ажил үйлчилгээний зориулалт: 110/6 кВ-ын Галуут дэд станцын 110 кВ-ын ШУС иж бүрнээр сольж шинэчлэх, ашиглах

110 кВ-ын Шугамын салгуур:

Үндсэн үзүүлэлт:

- Хэвийн гүйдэл I ном - 1500 А доошгүй
 - Хэвийн хүчдэл Uном – 127 кВ
 - Богино залгааг даах хэвийн гүйдэл кА, хугацаа сек 40/4
 - Тоноглолын өндөрийг бусад холбогдож ажиллах тоноглолуудтай уялдуулж хийнэ.
 - Ажлын хэсэг нь хэвтээ чиглэлд 90 градусаар тасардаг байна
-
- Шугамын салгуур нь оролт болон гаралтандаа газардуулгын хутгаар тоноглогдсон байна.
 - Контактын эсэргүүцэл багатай, мөсжилтэд тэсвэртэй, таслах залгах үйлдэлийн тоо өндөртэй байх
 - Тоноглолын хийгдсэн материалын чанар сайн бол давуу болно. /хэт хүчдэл, богино залгааны гүйдэл тэсвэрлэх чадвар, механик доргио, динамик цохилтод тэсвэр сайтай байх /
 - Нийлүүлэгч компани нь Эрчим хүчний угсралтын тусгай зөвшөөрөлтэй /110 кВ-ын / хугацаа дуусаагүй /сунгалт хийгдсэн/ байх.
 - Гүйцэтгэгч компани нь сүүлийн нэг жилд энэ төрлийн ажил хийсэн бол давуу болно.
 - Шугамын салгуурын суурь, их бие, удирдлага, кабель бусад тоноглолуудыг нийлүүлэгч тал иж бүрнээр нь нийлүүлж, угсарч ажилд оруулж хүлээлгэж өгнө.
 - Угсралтанд шаардагдах машин тоног төхөөрөмж, ажлын бүх зардлыг нийлүүлэгч тал хариуцна.
 - Уурхайн уулын ажилтай уялдуулж ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргаж мөрдөж ажиллана.

- Шугамын салгуур нь механикаар залгах, таслах, болон алсын удирдлагаар залгаж, таслах /цахилгаан мотор/ үйлдэл хийдэг байна.
- Битүүмжлэгдсэн самбар шит байна IP55
- Салгуур болон газардуулгын хутгууд нь цахилгаан байгууламжын техник ашиглалтын дүрмийн дагуу үйлдэл андуурхаас сэргийлсэн хориг түгжээтэй байна.
- Тоног төхөөрөмж стандартын дагуу суурьлуулж, газардуулга хийгдэнэ.
- 110 кВ-ын ИХБ-ийн олон улсын стандарт шаардлага хангасан сүүлийн үеийн дэвшилтэт технологид суурилсан MNS GOST стандартуудыг хангасан байна.
- Чанарын удирдлагын ISO сертификат бүхий үйлдвэрийн бүтээгдэхүүн байх.
- Тоног төхөөрөмж болон дагалдах хэрэгсэлүүд нь загварын туршилтанд орж баталгаажсан байна.
- Үйлдвэрийн туршилт хийгдэж баталгаажсан байна.
- Угсралтын болон ашиглалтын зааврыг Монгол хэл дээр ирүүлнэ.
- Гарал үүслийн болон чанарын сертификат ирүүлнэ.
- Баталгаат хугацаа: Хамгийн багадаа 12 сар, угсарч суурилуулан хүчдэлд залгасан өдрөөс хойш
- Тавигдсан тоноглолуудад 5-аас доошгүй жилийн баталгаа өгсөн байна.
- Тоноглолын техник ашиглалт, ажиллагаа программ хангамж засвар тохируулгын талаар дэлгэрэнгүй сургалт явуулах
- Тавигдсан хамгаалалтын сурах бичиг, техникийн схем, монтажийн схем, релены микросхемүүд, зургийг хавсаргаж үлдээх /монгол хэл дээр/
- -45-аас +50 градуст темпратурт, 80% чийгшилд ажиллах чадвартай байх
- Олон хувилбар тэжээлийн системтэй байх /Батерей ~110.220:-110,220В /
- Удирдлага, монтажны кабелиудыг бүрэн стандартын дагуу хийх
- Угсралт, туршилт, тохируулгын ажлыг гүйцэтгэгч тал хийж гүйцэтгэнэ.
- Угсралт, туршилт, тохируулгын ажлыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай уялдуулж богино хугацаанд чанартай хийж гүйцэтгэнэ.
- Салгуур залгаатай салгаатай байрлал төлөвийн склада хяналтын системд оруулж өгөх
- Гүйцэтгэгч компани өөрийн хөрөнгийн тусгай зориулалтын машинтай байх

Эрчим хүчний яамны Ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл 03.2.4 –ийг хангасан байх

Боловсруулсан: ТБХ-ийн инженер

Хянасан: ТБХ-ийн дарга



Д.Батболд

Х.Хашбат